Гарцны чанх дэргэд байрлах хаалт маягийн төхөөрөмж байж болох юм. Улаан гэрэл асаж, явган гарцаар гарах цаг явж эхлэнгүүт машинуудыг тусгаарлан хорих хаалт автоматаар дээшлэн гарч ирээд дуусахад доошлон хураагдана. Ингэснээр зарим нэг бүдүүлэг жолоочдыг албан хүчээр дүрмийг нь баримтлуулж, тогтоон хорино. Гэрлэн дохиотой ижил системтэй.

Би машинууд эзэн нь согтууруулах бодис хэрэглэсэн үед онгойхгүй өөрөө өөрийгөө түгждэг болно гэж сонссон. Мөн л адил хүн өөрийн ухамсраар иргэний үүргээ хариуцлагатай-гаар гүйцэтгэж чадахгүй бол албан хүчээр гүйцэтгүүлнэ. Машиндаа орохдоо өөрийн хурууны хээг таниулж, дараа нь үлээх бөгөөд эрүүл эсэхийг илгээж тогтоож болно.

Гарц эсвэл булан тохойд хүүхдэд зориулсан лед дэлгэц суурилуулж, туслаж болно. Замаа мэдэхгүй будилж яваа хүүхэд гэрлээ мэдэхгүй хүүхэд эсвэл хаана явааг аа мэдэхгүй хүүх-дүүдэд туслах зориулалттай энэхүү самбар нь хотын төв дундаа тухайн дүүргийн замын байгууламжийг тод харуулах агаад төөрсөн гэх мэт асуудалтай хүүхдүүдэд тус хүргэх юм. Хаана гарц байгааг, хаана байхгүйг ч тэмдэглэлт болох ажээ.

Эсвэл зүгээр л хотоо гэрэлжүүлэх явдал шийдэл байж магад. Оройн цагаар харанхуй, мухар гудамж, барилга хоорондын хэсгийг бүрэн гэрэлжүүлж, камераар хангах юм. Хэн нь ч хэнээ харахгүй осол гарч ч болох шүү дээ. Камержуулж, гэрэлтэй болгосноор хүн харахгүй мөргөх, машин харахгүй урдуур нь орох гэх мэт ослууд багасна. Мөн осол гарсан ч камергүй, мухар гудамж байсан гэх мэтчилэн элдэв зүйлийн маргаан гарахгүй.

Машины осол аюултай ч ачааны машин, автобусны осол бүр ч дор. Хүнээс хэд дахин өндөр тээврийн хэрэгсэл жолоодож буй жолоочийн харааны түвшинд дундаж өндөртэй хүн арай хийн харагддаг. Үүнээс харахад хүүхэд огт харагдахгүй нь тодорхой байна. Тэгвэл энэ төрлийн машины хошуунд жижиг камер байрлуулж, түүнийг үзүүлэх дэлгэцийг жолоочийн нүдний түвшинд ойр, хяналтын самбар маягаар тавина. Ингэснээр хүүхдүүд болон элдэв амьтныг харалгүй дайрах тохиолдол багасна.

Бүхнийг чадагч ид шидийн хүч надад байсан бол цаг үргэлж энэ дэлхийгээ гэрэлтүүлж, хүүхэд бүрийн гэртээ хүрэх замыг заах сан. Аюул осол бүрийг зогсоож, аз жаргалыг цогцлоох сан. Газар дэлхийн өнгөт цэцгийг хайхрамжгүй гишгэлэн хэмхлэх мэт алтан дэлхийн гоо цэцэг болсон хүүхэд багачуудын амь амьдрал, хүсэл мөрөөдлийг хурдны машинд дэвсүүлэн унтраах бус хүүхэд бүрийг нандигнан хамгаалъя.